LIVEWORKSHEETS

11-р анги Сонгууль

1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу.

A	Сонгууль	1	Тухайн улсын нийт иргэд сонгуульд оролцох эрхтэй байх
B	Сонгуулийн бүх нийтийн зарчим	2	Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх
C	Сонгуулийн тэгш эрхийн зарчим	3	Сонгуулийн эцсийн үр дүн иргэдийн санал хураалтаар шийдэгдэх
D	Шууд сонгох зарчим	4	Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй, санал бүр ижил жинтэй байх
E	Чөлөөтэй сонгох зарчим	5	Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй, зөвхөн өөрийн үзэмжээр саналаа өгөх
F	Саналаа нууцаар гаргах зарчим	6	Сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч шахалтад орохгүйгээрсаналаа чөлөөтэй илэрхийлэх

2. Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг тогтолцоог . . . . . гэнэ.
3. Нийт сонгогчдын 50%-аас дээш санал авсан бол . . . . . .
4. Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламентын суудал хуваарилах арга, дүрэм, журмын цогцыг . . . . . гэдэг.
5. Зарим улс орнуудад 21, 22 наснаас сонгуульд санал өгөх эрх эхэлдэг бол Монгол улсад 18 насанд хүрсэн эрх зүйн чадамж бүхий иргэд сонгуульд санал өгөх эрхтэй байдаг. Энэ нь улс төрийн сонгуулийн эрхийн . . .. шалгуур юм.

A. Сонгох эрхийн шалгуур
B. Сонгогдох эрхийн шалгуур
C. Төрийн албаны шалгуур
D. Төрийн жинхэнэ албаны шалгуур
E. Эдгээрээс өөр

LIVEWORKSHEETS

6. 2008 оны парламентын сонгуульд Монгол улсын иргэн Бат-Аригун Ардчилсан намаас нэр дэвшин сонгуульд өрсөлдөж, улмаар тойрогтоо өрсөлдөгчөөсөө илүү олон санал авч, Монгол улсын Их хурлын гишүүн болсон. Энэ нь сонгуулийн аль тогтолцоонд хамаарах вэ?

A. Дийлэнх олонхийн
B. Хувь тэнцүүлэх тогтолцоо
C. Холимог тогтолцоо
D. Пропорциональ тогтолцоо
E. Тохирох өгөгдөл алга

7. Иргэд хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч эсвэл улс төрийн нам, эвслээс сонголт хийх зайлшгүй нөхцөлийг . . . . . гэнэ.

8. Монгол улсад 1924 оноос эхлэн сонгууль болж байсан ч 1951 он хүртэл энэ нь зөвхөн . . . . . сонгууль байв.

9. Сонгуулийн аль тогтолцоонд санал гээгдэх асуудал хамгийн их гардаг вэ?

A. Харьцангуй олонх мажоритар
B. Энгийн олонх мажоритар
C. Дийлэнх олонх мажоритар
D. Пропорционал
E. Холимог

10. Сонгогч гэж хэнийг хэлэх вэ?

A. Хорих ял эдэлж буй иргэн
B. Аль нэг намын гишүүн
C. 25 насанд хүрсэн иргэн
D. Гадаадын харьяат иргэн
E. Сонгуулийн эрх бүхий иргэн

LIVEWORKSHEETS